



**АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН НЭГДСЭН ХОЛБОО  
НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН  
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2026 оны 02 сарын 05 өдөр

Дугаар 3/11/26

Улаанбаатар хот

**Дүрэм батлах тухай**

Аялал жуулчлалын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дахь хэсэг, Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны дүрмийн 28 дугаар зүйлийн 28.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Аялал жуулчлал, Зочлох үйлчилгээний мэргэжлийн боловсролын сургууль”-ын Төлөөлөн удирдах зөвлөлийн дүрмийг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны гүйцэтгэх захирал М.Нарангэрэл-д даалгасугай.
3. Тогтоол батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдсүгэй.

**УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА**



**О.МӨНХНАСАН**

“Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо” ЦЭХХ-ийн  
Удирдах зөвлөлийн 2023 оны 12 сарын 27 өдрийн  
21 тоот тогтоолын хавсралт



## АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗОЧЛОХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Аялал жуулчлал, Зочлох үйлчилгээний мэргэжлийн боловсролын сургуулийн Удирдах зөвлөлийн дүрмийг МБТБС-ын тухай хуулийн 26-р зүйл, Боловсрол шинжлэх ухааны сайдын 2023 оны 12-р сарын 27-ны өдрийн А/584 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын удирдах зөвлөлийн нийтлэг дүрэм”-ийг үндэслэл болгон боловсруулав.
- 1.2. Монгол улсын боловсролын сайдын 2024 оны 10-р сарын 28-ны өдрийн А/166 тоот тушаалаар батлагдсан “Удирдах зөвлөл” нь хуульд заасан хугацаанд үйл ажиллагаа явуулна.
- 1.3. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага /цаашид сургалтын байгууллага гэх/-ын удирдах зөвлөлийн үйл ажиллагаанд холбогдох харилцааг энэхүү нийтлэг дүрмээр зохицуулна.
- 1.4. Сургалтын байгууллагын өөрийн удирдлага нь “Удирдах зөвлөл” байна.
- 1.5. Удирдах зөвлөл нь Монгол улсын Үндсэн хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль эдгээртэй нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн баримт бичиг болон энэхүү дүрмийг мөрдөнө.

### Хоёр. Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн

- 2.1. Удирдах зөвлөл нь МБТБС-ын тухай хуулийн 26.4 заасны дагуу 9 гишүүнээс бүрдэх бөгөөд үүсгэн байгуулагчийн төлөөлөл, орон нутгийн өөрөө удирдах байгууллагын төлөөлөл, сургалтын байгууллагын хамт олны төлөөлөл, түншлэгчийн төлөөлөл, төгсөгчийн төлөөллөөс бүрдэнэ.
- 2.2. Сургалтын байгууллага нь нийтлэг дүрмийн 2.2-т зааснаар Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлуулна.
- 2.3. Удирдах зөвлөлийн даргыг нийт гишүүдийн олонхын саналаар сонгоно.
- 2.4. Удирдах зөвлөлийн гишүүд нь нийтлэг дүрмийн 2.4-ийн 1,2,3,4-т заасан хориглолтыг мөрдөн ажиллана.
- 2.5. Удирдах зөвлөлийн ажлын албаны болон нарийн бичгийн даргын үүргийг сургалтын байгууллагаас томилогдсон ажилтан гүйцэтгэж хэвийн үйл ажиллагааг ханган ажиллана.

## Гурав. Удирдах зөвлөлийн чиг үүрэг

3.1. Удирдах зөвлөл боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, үүсгэн байгуулагчийн бодлого, шийдвэрийг үндэслэн МБТБС-ын тухай хуулийн 26.5, 26.6-д зааснаас гадна дор дурьдсан үүргийг хэрэгжүүлнэ.

3.1.1. "Аялал жуулчлал, Зочлох үйлчилгээний мэргэжлийн боловсролын сургуулийн дүрэм"-ийг батлах

3.1.2. Сургалтын байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тоог хэлэлцэх

3.1.3. Сургалтын байгууллагын тухайн жилийн төсвийн төлөвлөлтийг хэлэлцэх, гүйцэтгэлд хяналт тавих

3.1.4. Хандив, өөрийн болон туслах үйл ажиллагааны орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад санал, дүгнэлт гаргах

3.1.5. Сургалтын байгууллагын жил бүрийн элсэлт, төгсөлтийн судалгаа, шинжилгээ, үйл ажиллагааг хянан хэлэлцэж, санал, дүгнэлт гаргах

3.1.6. Сургалтын байгууллагад хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийг хэлэлцэж, санал, дүгнэлт гаргах, хяналт тавих

3.2. Удирдах зөвлөлийн даргын эрх, үүрэг

3.2.1. Удирдах зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудал, хуралдааны дэг, хугацаа, зохион байгуулалтын арга хэмжээ авч, шийдвэрийг албажуулах, хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авах

3.2.2. Удирдах зөвлөлийн гишүүд, нарийн бичгийн даргад ажил үүргийн хуваарийг тогтоох, үүрэг даалгавар өгөх, биелэлтийг хянах, шаардлагатай гэж үзвэл уг асуудлыг удирдах зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх

3.2.3. Удирдах зөвлөлийн ажлын төлөвлөгөөг батлах, гүйцэтгэлд нь хяналт тавих

3.3. Удирдах зөвлөлийн гишүүний эрх, үүрэг:

3.3.1. Удирдах зөвлөлийн хуралдаанд идэвхтэй оролцож, хуралдааны дэгийг баримтлан, санал, дүгнэлт гаргах

3.3.2. Удирдах зөвлөлөөс хариуцуулсан ажил үүргийг биелүүлэх, үр дүнг танилцуулах

3.3.3. Удирдах зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт тавих, хуралдаанд асуудал хэлэлцүүлэх, холбогдох мэдээлэл авах

3.3.4. Сургалтын байгууллагын нэр хүндийг өсгөх, санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх ажилд идэвх санаачлагатай оролцох, сургалтын байгууллагыг хөгжүүлэх талаар удирдах зөвлөлөөс гаргасан бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх, дэмжлэг туслалцаа үзүүлэх

3.3.5. Хувийн ашиг сонирхолоос ангид, ёс зүйн хэм хэмжээг баримтлан ажиллах

3.4. Дараах тохиолдолд Удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрх МБТБС-ын тухай хуулийн 26.4-т заасан хугацаанаас өмнө дуусгавар болно.

3.4.1. Эрүүл мэндийн болон бусад хүндэтгэн үзэх шалтгаанаар чөлөөлөгдөх хүсэлтээ өөрөө гаргасан

3.4.2. Гэмт хэрэг үйлдсэн болох нь шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор тогтоогдсон

3.4.3. Өөр ажилд шилжих болсон

3.4.4. Үүсгэн байгуулагчийг төлөөлөх гишүүний албан тушаал өөрчлөгдсөн

3.4.5. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр Удирдах зөвлөлийн хуралдаанд гурав ба түүнээс дээш удаа оролцоогүй.

3.5. Удирдах зөвлөл албан бичгийн хэвлэмэл хуудастай байна.

#### **Дөрөв. Удирдах зөвлөлийн хуралдаан**

4.1. Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан, шийдвэр нь тогтоол хэлбэртэй байх бөгөөд гишүүдийн 2/3-оос доошгүй нь оролцсоноор хүчин төгөлдөр болно.

4.2. Хуралдааныг танхим, цахим, эсхүл холимог хэлбэрээр зохион байгуулж болно.

4.3. Удирдах зөвлөл ээлжит хуралдааныг улирал тутамд нэгээс доошгүй удаа, шаардлагатай тохиолдол ээлжит бус хуралдааныг Удирдах зөвлөлийн дарга эсхүл нийт гишүүдийн 5-аас доошгүй гишүүний санал болгосноор хуралдуулна.

4.4. Удирдах зөвлөлийн хуралдааны товьг ажлын таваас доошгүй өдрийн өмнө зарлаж, нарийн бичгийн дарга холбогдох мэдээлэл, материалыг гишүүдэд хүргэнэ.

4.5. Удирдах зөвлөлийн дарга хуралдааныг даргална. Түүнийг эзгүйд удирдах зөвлөлийн даргын томилсон гишүүн даргалж хуралдаанаас гарсан шийдвэрийг Удирдах зөвлөлийн даргад танилцуулан албажуулна.

4.6. Удирдах зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын дарааллыг хуралдаан даргалагчийн саналыг харгалзан хэлэлцэж тогтооно.

4.7. Удирдах зөвлөлийн гаргасан шийдвэр хуульд нийцээгүй тохиолдолд Удирдах зөвлөл шийдвэрээ өөрөө хүчингүй болгоно.

4.8. Удирдах зөвлөлийн хуралдаанд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан сургалтын байгууллагын багш, ажилтан, суралцагчийн төлөөллийг оролцуулан санал, хүсэлт, тайлбарыг сонсож, мэдээлэл авч болно.

4.9. Хэлэлцэх асуудалтай холбогдолтой мэдээлэл, танилцуулга, тайлбарыг хэлэлцүүлэх гишүүн хийх бөгөөд холбогдох материалыг урьдчилан тараасантай холбогдуулан гишүүдээс асуулт, санал дүгнэлт гаргаагүй бол санал хураалт явуулж болно.

4.10. Удирдах зөвлөлийн хуралдаанд аливаа асуудлыг шийдвэрлэхэд гишүүн бүр нэг саналын эрхтэй байна. Харин хуралдааны ирц буюу бусад шалтгаанаар санал тэнцсэн тохиолдолд дахин санал хураах бөгөөд санал дахин тэнцсэн бол Удирдах зөвлөлийн даргын саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

4.11. Удирдах зөвлөлийн хуралдаанд оролцох боломжгүй гишүүн нь тухайн хэлэлцэх асуудлаар саналаа бичгээр, эсхүл цахимаар ирүүлсэн тохиолдолд түүнийг хуралдаанд сонсгож хэлэлцүүлэх бөгөөд асуудлыг дэмжсэн болон дэмжээгүй санал өгсөн бол хуралдаанд оролцож санал өгсөнд тооцно.

#### **Тав. Бусад зүйл**

5.1. Энэхүү нийтлэг дүрмийг зөрчсөн хуулийн этгээд, албан тушаалтан Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

5.2. Удирдах зөвлөлийн даргыг хараахан сонгож амжаагүй эхний хуралдааныг гүйцэтгэх удирдлага даргалан эхлүүлж, Удирдах зөвлөлийн даргыг сонгосны дараа түүнд даргалах үүргийг хүлээлгэн үйл ажиллагааг үргэлжлүүлнэ.

----oOo----